



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/82

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” төслийн хүрээнд хийгдэх “Ханх сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажилд “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”, “Нью Урбанизм” ХХК-тай орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай мэдээ мэдээлэл, холбогдох саналыг өгч хамтран ажиллахыг Ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
дугаар сарын 17 өдрийн А/Х.2  
дугаар захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга М.Хуягбаатар-Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн дэд дарга Б.Оюунтуяа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүдэд:

М.Оюунбат- Ханх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Л.Даваабаяр- Ханх сумын Засаг дарга

Б.Ганзориг- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

П.Мөнхжаргал -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Х.Даваасүрэн -Аймгийн ерөнхий архитектур

Ё.Батсайхан- Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Л.Бямбасүрэн-Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын ахлах  
байцаагч (хошууч)

Д.Баасандулам-Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын  
хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: М.Батчимэг- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх  
төслийн Хөвсгөл аймаг дахь ажилтан

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_